650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	10.00	10.00	0.00	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	18.00	18.00	0.00	100.0
650010	Гэрээт ажилтан	8.00	8.00	0.00	100.0
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	6.00	6.00	0.00	100.0

2.6 Аудит хийсэн нэгтгэсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	65,929,542.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	65,929,542.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	60,723,340.68

	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	89,315.68
	Гэрэл,цахилгаан	89,315.68
2104	Хангамж, бараа материалын зардал	7,929,850.00
210402	Тээвэр, шатахуун	7,753,850.00
	Шуудан холбоо интернэтийн төлбөр	176,000.00
	Эд хогшил,урсгал засварын зардал	3,755,000.00
	Урсгал засвар	3,755,000.00
	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил,үйлчилгээний төлбөр,хураамж	6,417,375.00
	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,201,800.00
	Даатгалын үйлчилгээ	127,575.00
	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	42,531,800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	42,531,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,206,201.32
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,206,201.32
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт,нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	33,270.00
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	5,172,931.32
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	65,896,272.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	65,896,272.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	46,471,800.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	19,424,472.00
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-33,270.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	33,270.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Давст сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь оновчтой бодлого зохицуулалтаар ард иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлж, орон нутгаа хөгжүүлэх гэсэн зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Хөдөлмөрийн тухай хууль - Шинэчлэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсан.
- ✓ Төрийн албаны тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 05-ны өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр нэмэлт өөрчлөлтүүд оруулсан байна.

- ✓ Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 01-ний өдөр, 8 дугаар сарын 29-ний өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчаас эрсдэлд суурилсан дотоод аудит хийгдээгүй.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Давст сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Давст сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар журмын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 214.3 сая төгрөг болж, өмнөх оноос 27.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/	
			Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Төрийн сангийн харилцах	186.6	214.3	+27.7	114.8
Дүн	186.6	214.3	+27.7	114.8

Эх сурвалж: Давст сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 214.3 сая төгрөг төрийн сангийн урсгал санхүүжилтийн харилцах дансанд байршиж байна. Үүнд: Орон нутгийн ерөнхий орлого 79.3 сая төгрөг, Орон нутгийн хөгжлийн сан 60.1 сая төгрөг, хоршоо хөгжүүлэх сан 74.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 227.3 сая, эцсийн үлдэгдэл 148.9 сая төгрөг болж, 78.4 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	0.1	0.00	-0.1
Төлбөртэй үйлчилгээний авлага	74.2	0.0	-74.2
Зээлийн хүүгийн авлага	2.0	3.0	+1.0
Байгууллагаас авах авлага	14.0	1.2	-12.8
Хувь хүмүүсээс авах авлага	26.6	26.6	0.0
Зээлийн авлага	110.3	118.1	+7.8
Дүн	227.3	148.9	-78.4

Эх сурвалж: Давст сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэл буурахад Эрүүл мэндийн төвийн төлбөрт үйлчилгээний санхүүжилт 74.2 сая төгрөг, ажиллагчидтай холбогдсон авлага 0.1 сая төгрөг, байгууллагаас авах авлага 12.8 сая төгрөгөөр буурсан нь голчлон нөлөөлжээ. Мөн хоршоо хөгжүүлэх сангийн зээл, хүүгийн авлага өссөн байна.

3.5.3 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 291.2 сая, эцсийн үлдэгдэл 130.7 сая төгрөг болж, 160.5 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №3 Бараа материалын үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалтын материал	0.4	0.0	-0.4
Эм боох материал	24.5	0.0	-24.5
Бичиг хэргийн материал	20.3	1.0	-19.3
Аж ахуйн материал	122.1	12.0	-110.1
Сэлбэг хэрэгсэл	0.3	0.1	-0.2
Түлш шатах тослох материал	1.5	0.0	-1.5
Барилгын засварын материал	0.7	0.0	-0.7
Хүнсний материал	12.5	0.0	-12.5
Бусад хангамжийн материал	109.0	113.7	4.7
Мал амьтад	0.0	4.0	4.0
Дүн	291.2	130.7	-160.5

Эх сурвалж: Давст сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Улсын төсвийн байгууллага болох Ерөнхий боловсролын сургууль, Эрүүл мэндийн төв, Соёлын төв, Цэцэрлэгийн бараа материалыг шилжүүлж тайлагнасантай холбоотой буурсан байна.

3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 8,692.0 сая, эцсийн үлдэгдэл 2,668.0 сая төгрөг болж, 6,024.0 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга, байгууламж, орон сууц	4,590.5	550.9	-4,039.6
Хуримтлагдсан элэгдэл	-290.9	-128.0	-162.9
Авто тээврийн хэрэгсэл	332.0	129.1	-202.9
Хуримтлагдсан элэгдэл	-149.1	-130.2	-18.9
Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,072.8	98.4	-974.4
Хуримтлагдсан элэгдэл	-564.5	-256.0	-308.5
Тавилга, аж ахуйн эд хогшил	419.1	58.9	-360.2
Хуримтлагдсан элэгдэл	-205.3	-67.7	-137.6
Зам гүүрний барилга байгууламж	1,462.0	1,389.8	-72.2
Хуримтлагдсан элэгдэл	0.0	72.2	72.2

Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	169.5	0.0	-169.5
Бусад үндсэн хөрөнгө	496.3	378.2	-118.1
Хуримтлагдсан элэгдэл	-98.3	-119.9	21.6
Ном	28.3	0.3	-28.0
Программ хангамж	2.5	0.5	-2.0
Хуримтлагдсан элэгдэл	-1.6	-0.8	-0.8
Бусад биет бус хөрөнгө	118.9	61.9	-4.3
Дүн	8,692.0	2,668.0	-6,024.0

Эх сурвалж: Давст сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурахад гүйцэтгэлээр санхүүжих улсын төсөвт байгууллагуудын хөрөнгийг шилжүүлснээс голчлон нөлөөлсөн байна. Тайлант онд төсвийн хөрөнгөөр 72.5 сая, шилжүүлэн авсан хөрөнгө 7.6 сая, бусад эх үүсвэрээс 118.2 сая, нийт 198.3 сая төгрөгийн хөрөнгөөр нэмэгдэж, бүтцийн өөрчлөлтөөр 2,337.9 сая төгрөгийн шилжүүлж, 60.8 сая төгрөгийн хөрөнгийг акталсан байна.

3.5.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 11.1 сая, эцсийн үлдэгдэл 2.4 сая төгрөг болж, 8.7 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №5 Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
Ажилчидтай холбоотой өглөг	2.1	1.4	-0.7	66.7
Байгууллагад төлөх өглөг	9.0	1.0	-8.0	11.1
Хувь хүмүүст төлөх өглөг	0.0	0.0	0.0	0.0
Нийт дүн	11.1	2.4	8.7	21.6

Эх сурвалж: Давст сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөр дансны үлдэгдэл буурсан нь ажилчидтай холбоотой болон байгууллагад төлөх өглөг буурснаас шалтгаалжээ.

3.5.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 8,075.2 сая, эцсийн үлдэгдэл 3,094.1 сая төгрөг болж, 4,981.1 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт № 6. Засгийн газрын хувь оролцоо

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт+/, бууралт /-/	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,534.7	1,236.5	-1,298.2	48.8
Хуримтлагдсан үр дүн	4,242.4	1,407.0	-2,835.4	33.2
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,298.1	516.1	-782.0	39.8
Дүн	8,075.2	3,159.5	4,915.7	39.1

Эх сурвалж: Давст сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл буурсан нь тайлант үеийн үр дүн, хөрөнгийн дахин үнэлгээ буурснаас шалтгаалжээ.

3.5.7 Орлогын данс

Тайлант онд татварын орлого 158.7 сая, татварын бус орлого 62.2 сая, тусламж санхүүжилтийн орлого 1,547.6 сая, нийт 1,768.6 сая төгрөгийн үйл ажиллагааны орлого орсон байна.

3.5.8 Зардлын данс

Зардлын данстай холбоотой Төсвийн шууд захирагчид 66.3 сая төгрөгийн 1 алдаа илэрснийг залруулсан.

Давст сумын засаг даргын тамгын газар:

Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлсэн, дутуу хэрэгжсэн 3 төсөл арга хэмжээний 66.3 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэлд тусгаагүй байсныг бусад хангамжийн материалын хэсэгт бүртгүүлж залруулга хийлгэсэн.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Давст сумын ИТХ-ын 2022 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн орон нутгийн төсвийн тодотгол батлах тухай 8/01 дугаар тогтоолд зааснаар Давст сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч тайлант онд 100.9 сая төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 158.7 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 157.3 хувиар биелүүлсэн байна.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Давст сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны төсвийн төсөлд санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 602.9 сая, урьд оны үлдэгдлээс санхүүжих 58.0 сая, ОНХС-ийн шилжүүлгээр 155.9 сая, ХХС-ын урьд оны үлдэгдлээс 116.8 сая, татварын болон татварын бус орлогоос 100.9 сая, нийт 1,034.5 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Давст сумын 2022 оны төсвийг сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн А/15 дугаар тогтоолоор 1,034.5 сая төгрөгөөр баталж 2022 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн 8/01 дүгээр тогтоолоор тодотгол хийж анх баталсан дүнгээс 30.2 сая төгрөгөөр бууруулж 1,004.3 сая төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,004.3 сая төгрөгийн төсөв баталснаас орон нутгийн төсвөөс 731.6 сая, урьд оны үлдэгдлээс санхүүжих 82.6 сая, ОНХС-ийн шилжүүлгээр 155.9 сая, үндсэн үйл ажиллагааны орлогоос 34.2 сая төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 745.2 сая, ОНХС-ийн шилжүүлгээр 147.9 сая, үндсэн үйл ажиллагааны орлогоос 62.2 сая төгрөгийг санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 912.8 сая төгрөгийг зарцуулж, 5.4 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 912.8 сая төгрөг буюу 90.9 хувьтай байгаа нь зардлыг 5.4 сая төгрөгөөр хэмнэж, 135.0 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй гарснаас шалтгаалжээ.

Давст сумын ИТХ-ын 2022 оны тодотгосон төсөв батлах тухай 2022 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн 7/01 дүгээр тогтоолд зааснаар Давст сумын Засаг дарга тайлант онд 100.9 сая төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 183.7 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 182.1 хувиар биелүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар 65.9 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 60.7 сая төгрөгийг зарцуулж 5.2 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Давст сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Одгэрэл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Давст сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 32 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 0.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцож 8.0 сая төгрөгөөр тогтоосныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөхгүйгээр нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,699.9 сая төгрөгийн 0.5 хувь буюу 8.5 сая төгрөгөөс 80 хувиар тооцож 6.8 сая төгрөгөөр тогтоолоо. Материаллаг байдлыг шинж чанарын хувьд авч үзээгүй болно.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Давст сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн тухайн хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Давст сумын орон нутгийн орлогын төлөвлөгөө 183.7 сая төгрөг буюу 182.1 хувиар давж биелснээс аймгийн Засаг даргын 2022 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн А/697 дугаар захирамжийн дагуу сумын орон нутгийн давсан орлогоос 25.0 сая төгрөгийг аймгийн орон нутгийн орлогод татаж авсан байна.

Сумын 2022 оны татварын орлогын гүйцэтгэл зарим нэр төрлөөр тасарч, зарим нэр төрлөөр давж, нийт дүнгээр 57.8 сая төгрөгөөр давж биелсэн байна. Иймд төсвийн орлогыг бодитой төлөвлөж байхыг зөвлөмж болголоо.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 154 мэдээллээс хугацаандаа оруулсан 152 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна. Хугацаа болоогүй хүлээгдэж байгаа 2 мэдээлэл байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Давст сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар ОНХС-ын хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний хүрээнд бий болсон хөрөнгүүдийн өртгийг үнэн зөв тооцож бүртгэлд тусгаж байх албан шаардлага өгсөн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-
Албан шаардлага	1	7.6	1	7.6	100%
Зөвлөмж	-	-	-	-	-
Нийт дүн	1	7.6	1	7.6	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

4.7 Харьяа байгууллагуудын аудитын дүнгийн талаар

Давст сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 2 тусгай сан, нийт 8 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 6 байгууллагад дүгнэлт гаргаж, 2 санг түүвэрт хамруулсан.

Аудитад хамрагдсан Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа 6 байгууллагын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” санал дүгнэлт өгсөн байна.

Харьяа байгууллагуудад хийсэн аудитаар 66.3 сая төгрөгийн алдаа илэрснийг залруулсан.

Харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Давст сумын Засаг даргын тамгын газар	1	66.3	1	66.3						
	Дүн	1	66.3	1	66.3						

5.АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 82.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 25.0 сая төгрөгийн 3 алдааг залруулж, 57.8 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өглөө.

Орон нутгийн ерөнхий орлого:

Орон нутгийн ерөнхий орлогын санхүүгийн тайланд төвлөрүүлэх шилжүүлгийг 5.2 сая төгрөгөөр дутуу тайлагнасан байсныг залруулга хийлгэсэн.

Орон нутгийн хөгжлийн сан:

Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүгийн тайланд санхүүжилтийн 19.0 сая төгрөгийг малд ногдуулах албан татварын орлогоор буруу тайлагнасан байсныг залруулга хийлгэсэн.

Хоршоо хөгжүүлэх сан:

Хоршоо хөгжүүлэх сангийн санхүүгийн тайланд зээлийн хүүгийн авлагыг 0.8 сая төгрөгөөр илүү тайлагнасан байсныг залруулга хийлгэсэн.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Давст сумын 2022 оны татварын орлогын гүйцэтгэл зарим нэр төрлөөр тасарч, зарим нэр төрлөөр давж, нийт дүнгээр 57.8 сая төгрөгөөр давж биелсэн байна. Тухайлбал: Хөрөнгийн орлого 5.8 сая, галт зэвсгийн албан татвар 0.3 сая, шууд бус орлогын албан татвар 1.2 сая төгрөгөөр тасарч, Цалин хөлс шагнал урамшууллын орлого 31.1 сая, үйл ажиллагааны орлого 32.1 сая, Газрын төлбөрийн орлого 10.2 сая, Малын тоо толгойн албан татвар 14.4 сая төгрөгөөр давж биелсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэгт "Сум, дүүргийн Засаг дарга орон нутгийн төсвийн удирдлага, санхүүжилтийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 66.1.1 дэх заалтад "Тухайн шатны төсвийн төсөл, түүний тодотголын төслийг боловсруулах, хэлэлцүүлэх, батлуулах, төсвийн гүйцэтгэлийг зохион байгуулж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнах" Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1 дэх хэсэгт "Сумын Засаг дарга харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 59.1.7 дахь заалтад "хууль тогтоомж, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас энэ хуулийн 22.1-д заасан асуудлаар гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг хариуцан зохион байгуулах", 59.1.19 дэх хэсэгт "Нутаг дэвсгэрийнхээ татварын албыг удирдлагаар хангах, татварын орлогыг хууль тогтоомж, Хурлын шийдвэрийн дагуу төвлөрүүлэх, шилжүүлэх ажлыг зохион байгуулах" гэж заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ сумын татварын орлогыг бодитой төлөвлөөгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Сумын татварын орлогыг бодитой төлөвлөж батлуулах, хэрэгжилтийг хангаж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 9 дүгээр сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/сая төгрөгөөр/ Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Орон нутгийн ерөнхий орлого	1	5.2	1	5.2			1	5.2				
ОНХСан	1	19.0			1	19.0	1	19.0				
ХХСан	1	0.8			1	0.8	1	0.8				
Дүн	3	25.0	1	5.2	2	19.8	3	25.0				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт зөрчил	/сая төгрөгөөр/ Үүнээс				
		Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж	Хариуцлага тооцуулах албан шаардлага	Хууль, хяналтын байгууллагад

											шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Дүн									
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
Сумын татварын орлогыг бодитой төлөвлөөгүй байна.	1	57.8					1	57.8	
Дүн	1	57.8					1	57.8	
Нийт дүн	1	57.8					1	57.8	

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР

/М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

/Б.ОДГЭРЭЛ/

2023 оны 03 сарын 24-ний өдөр